БАТЛАВ:

ЗАСАГ ДАРГЫН

ОРЛОГЧ Л.ЭНХБАЯР

ТӨЛӨВЛӨСӨН ТАЛБАЙН ИНЖЕНЕРИЙН ШУГАМ СҮЛЖЭЭНИЙ ЗУРАГ, ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР

2025.05.09

Ховд хот

1	Ерөнхий агуулга	**Үндэслэл:** -Ховд аймгийн Иргэдийн төлөөлөгчдын хурлын 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 56 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 5.2-д Аймгийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө хийхээр батлагдсан -Аймгийн 2025 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан **Зорилго:** -Ховд аймгийн 2030 онд хүртэл хөгжүүлэх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилгоор хотжилттой холбогдон үүсэж буй хот байгуулалтын сөрөг үр дагаваруудыг багасгах бага, дунд орлоготой өрхүүдийн худалдан авах чадварт нийцсэн орон сууцны бүтээн байгуулалт бий болж, иргэд эрүүл аюулгүй орчинд ажиллаж амьдрах таатай орчинг бүрдүүлэх хотын төвлөрлийг багасгах, агаарын бохирдлыг бууруулах, шугам сүлжээг хөгжүүлэх төлөвлөлтийн шийдлийг боловсруулна.
2	Төлөвлөлтийн хязгаар, хамрах хүрээ	Төлөвлөсөн талбайн барилгажилт, тохижилт, орон зайн архитектурын шийдлийг тусгайлан авч инженерийн шугам сүлжээний төлөвлөгөөг боловсруулан
3	Боловсруулах байгууллага	Барилга хот байгуулалтын сайдын 2013 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 89 дүгээр тушаалаар батлагдсан “Хот байгуулалтын баримт бичиг, барилга, байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилга угсралтын ажил гүйцэтгэх, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох журам"-ын 1.1.2 хот, тосгоны ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, шугам сүлжээний, хот төлөвлөлтийн суурь судалгаа боловсруулах тусгай зөвшөөрөл бүхий аж ахуй нэгж байгууллага байна.
4	Захиалагч байгууллага	Ховд аймгийн Засаг даргын Тамгын газар
5	Шаардагдах хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр	Төсөвт өртөг: /Улсын болон орон нутгийн төсөв/
6	Боловсруулах үе шат	-Судалгаа, үнэлгээ, тооцоолол, -Төлөвлөлт
7	Боловсруулах хугацаа, тайлангийн бүрдэл	Захиалагч, гүйцэтгэгч талуудын хооронд гэрээгээр ЗӨВШИЛЦӨЖ / инженерийн шугам сүлжээний зураг боловсруулах хугацаанд магадлалын ерөнхий дүгнэлт хийлгэх хугацааг ороогүй болно
8	Судалгаа, үнэлгээ тооцооллын үе шатанд	**Архитектур орон зай**: - Тухайн газар нутгийн газар зүйн байршил, ус, ургамал, хөрс, байгалийн тогтоц, ландшафт болон өвөрмөц онцлогийг судлах,

	тавигдах шаардлага	- Одоогийн суурьшил ба архитектур орон зай бүрэлдэн бий болсон үйл явц, зайлшгүй хэрэгцээ шаардлагаас үүдэн хөгжсөн чиг хандлагыг тодорхойлох, **Газар зохион байгуулалт**: - Иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудын өмчлөл, эзэмшил, ашиглалтад байгаа газрын судалгаа гаргаж зориулалтаар нь ангилах, - Зөвшөөрөлгүй газар эзэмшиж буй болон эзэмшил газрын хэмжээнээс илүү талбай хашиж ашиглаж буй иргэн аж ахуй нэгж байгууллагын судалгаа гаргах, - Газар ашиглалтын талбайн балансыг одоогийн байдлаар гаргах, - Ундны усны эх үүсвэрийн хамгаалалт, хориглолт, хязгаарлалтын бүс, өндөржилт, үерийн далан суваг, байгалийн жалга, борооны ус, гадаргын ус зайлуулах шугам сүлжээ, хөрсний ус зайлуулах системийн хамгаалалтын бүсэд орсон эдэлбэр газрын судалгааг гаргах, **Гудамж, замын сүлжээ**: - Одоо байгаа авто замын сүлжээний судалгааг гаргах, хүчин чадал, замын өргөн, эгнээ, нийт урт, эрчмийн судалгаа, авто замын хүрэлцээ төрлөөр ангилах, уулзвар, гүүр болон нүхэн гарцын байршил, хүчин чадлыг тодорхой гаргах, **Нийгмийн дэд бүтэц**: - Одоо байгаа засаг захиргаа, төрийн байгууллагуудын бүтэц, байршил, үйлчлэх хүрээ, хүчин чадал, хүрэлцээг судлах, - Сургууль, цэцэрлэг, эмнэлэг, иргэдийн чийрэгжих спорт талбай, хамрах хүрээ, хүчин чадал, хүрэлцээг судлах, **Инженерийн бэлтгэл арга хэмжээ**: - Ундны усны эх үүсвэрийн хамгаалалт, хориглолт, хязгаарлалтын бүс, өндөржилт, үерийн далан суваг, байгалийн жалга, борооны ус болон гадаргын ус зайлуулах шугам сүлжээ, хөрсний ус зайлуулах системийн хамгаалалтын бүс болон бусад хамгаалалт, хориглолт, хязгаарлалтын бүсүүдийг тодорхойлж гаргах, **Дулаан хангамж**: - Дулааны хангамжийн нэгдсэн системд холбогдох шаадлагатай хэсгийн ачаалал, хамрах хүрээ, эдэлбэр газрын мэдээллийг гаргах, **Усан хангамж**: - Ус түгээх байруудын байршил, хамрах хүрээний судалгаа гаргах, - Төвлөрсөн шугам сүлжээний хамрах хүрээ, ус хэрэглээний одоогийн байдлыг тодорхойлох, **Ариутгах татуурга**: - Төлөвлөлтөнд хамрагдаж буй газрын ариутгах татуургын судалгаа гаргах **Цахилгаан хангамж**: Цахилгаан хангамжийн мэдээлэл, эх үүсвэрийн хүчин чадал, ачааллыг гаргах,
9	Төлөвлөлтийн үе шатанд тавигдах шаардалга	**Архитектур орон зай**: - Орон зайн бүсчлэлийн тогтолцоо, замын сүлжээг боловсронгуй болгох - Бүсчлэл тус бүрээр тавигдах үндсэн шаардлага болон газар ашиглалтын үүрэг, зориулалт, барилгын өндрийн дээд хязгаар буюу газар нутгийн өвөрмөц тогтоц, ундны усны ундаргыг цаашид хэрхэн хамгаалах хэтийн төлөвийг тодорхойлох, байгаль экологид аюулгүй, ногоон байгууламжийг дэмжсэн нутаг дэвсгэрийн төлөвлөлт хийх - Төлөвлөлтийн хамрах хүрээнд авто замын сүлжээ болон бүсчлэлийг төлөвлөх **Газар зохион байгуулалт:** - Газар ашиглалт, талбайн балансыг гаргах

		- Газар шинэчлэн зохион байгуулах төсөл хэлбэрээр нарийвчлан төлөвлөх, үүссэн суурьшлыг оновчтой зохион байгуулах төлөвлөлтийн шийдлүүдийг дэвшүүлэх, үе шатуудад хуваах **Гудамж, замын сүлжээ:** - Ерөнхий төлөвлөгөөний гудамж, замын сүлжээг нэгдсэн систем байхаар төлөвлөнө. - Өндөржилт, улаан шугам, инженерийн бэлтгэл арга хэмжээ, дэд бүтэц, инженерийн шугам сүлжээний төлөвлөлтийн дэвсгэр зургийг үндэслэн боловсруулах - төлөвлөлтөнд тусгах **Дулаан хангамж:** - Дулааны эрчим хүчний хэрэглээний тооцоог барилгажилтын үе шаттай уялдуулан хүснэгтээр үзүүлсэн байх - Төлөвлөж буй барилга байгууламжууд нь дулааны эрчим хүчний хэмнэлттэй, ногоон барилгад тэмүүлсэн байх - Дулаан дамжуулах төвийн дараах түгээх сүлжээг төлөвлөж харуулсан байх **Усан хангамж:** - Ус хэрэглээний нэгдсэн тооцоог төлөвлөлтийн үе шатаар нарийвчлан хийх, хэрэглэгчийн шугамыг дулааны шугамтай хамт бүсчилсэн байдлаар төлөвлөх **Ариутгах татуурга:** - Ариутгах татуургын шугам сүлжээний трассыг сонгохдоо ундны усны хамгаалалтын бүсийн дэглэмийн журмыг тооцож төлөвлөх - Инженерийн шугам сүлжээний төлөвлөлт бусад дэд бүтцийн шугам сүлжээтэй уялдаж байхаар төлөвлөх
10	Ашиглах материал	Монгол Улсын хуулиуд: - Хот байгуулалтын тухай хууль болон холбогдох бусад хуулиуд - Хот, суурин газрыг дахин хөгжуулэх тухай хууль -Хөгжлийн бэрхшээлтэй хуний эрхийн тухай хууль - Усны тухай хууль - Байгаль орчны тухай хууль - Гамшгаас хамгаалах тухай хууль - Галын аюулгүй байдлын тухай хууль - Газрын тухай хууль - Монгол улсын иргэнд газар емчлуулэх тухай хууль - -Барилгын тухай хууль -Эрчим хучний тухай хууль Бодлогын баримт бичиг, төсөл, хөтөлбөрүүд: - Ховд хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө-2030 он мөрдөх Норм дүрэм: - Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм /БНбД 30-01-04/ - Хот, суурины хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах аргачилсан заавар /УББ 11-202-00/ - Инженерийн шугам сүлжээний зураглалын ажил [БД 11-105-06/-ыг үндэслэн байр зүйн зургийн тодруулалт хийсэн дэвсгэр зураг ашиглах - Барилга байгууламжийн инженер-экологийн судалгаа /Бд 11-102-07/ - Барилгын нэгж талбайн төсөвт өртөг,төсвийн жишиг үнэлгээ / БД 81-106-16/ - Барилга байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүй дурм /БНбД 21-02-02/ - Барилгын орчны тохижилтын ажил /БНбД 3,01,06-90/ Бусад шугам сүлжээний зураг боловсруулах холбогдох норм дүрмүүд.
11	Ажлын иж бүрдэл	Зураглалын иж бүрдэл: - Одоогийн байдал, судалгааны танилцуулга Төлөвлөлтийн зураглал

		Зураглалын материал: - Дэвсгэр зураг, байршлын схем - Геодези байр зүйн зураглал - Инженерийн шугам сүлжээний иж бүрэн зураг төсөл - Бусад ажлын зураг Зураг төслийн баталгаажуулалт: - Зураг төсөлд иж бүрэн магадлал хийлгэх - Холбогдох шугам сүлжээний ашиглагч байгууллага болон мэргэжлийн байгууллагуудтай зөвшилцөх - Зураг төсөлд инженер геологийн дүгнэлтээр хөрсний ус илрэх тохиолдолд нэмэлт хамгаалах шийдлүүдийг тусгах Бусад иж бүрдэл - Хэсэгчилсэн шугам сүлжээний товч танилцуулга /* doc/ - Хэсэгчилсэн шугам сүлжээний прэсэнтейшн /power point/ - Хэсэгчилсэн шугам сүлжээний төлөвлөлтийн онцлогийг харуулсан анимэйшн 2 минутаас багагүй байх - Хэсэгчилсэн шугам сүлжээний ерөнхий харагдах байдал /3D зураг/ самбарууд Зураг төслийг хэвлэмэл байдлаар 4%, софт хэлбэрээр 4% захиалагчид хүлээлгэн өгөх.Төслийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах Төсөв тооцоо гаргах / ажилбар тус бүрээр

ХЯНАСАН:
БОНХОБТХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Б.АНХБАЯР

БОЛОВСРУУЛСАН:
БОНХОБТХЭЛТСИЙН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Б.ТҮМЭНДЭМБЭРЭЛ

БОЛОВСРУУЛСАН:
БОНХОБТХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН М.БАЯРЖАРГАЛ